



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 2/331

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын
эд хөрөнгийг данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамжийн материалын дансанд бүртгэлтэй нийт 7,868,400.00 (долоон сая найман зуун жаран найман мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар (П.Нэмэхбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар (П.Нэмэхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн 44 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар

Д/Д	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
							Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх Данс	Бүртгэх Данс
1	Таблет /Galaxy A7/ БЗДЦГ	Galaxy A7	2021.01.01	хэвийн	ш	1	655,700.00	655,700.00	502,703.33	152,996.67	Бусад хангамжийн материал	Машин, тоног төхөөрөмж
2	Таблет /Galaxy A7/ БЗДЦГ	Galaxy A8	2021.01.01	хэвийн	ш	3	655,700.00	1,967,100.00	1,508,109.99	458,990.01	Бусад хангамжийн материал	Машин, тоног төхөөрөмж
3	Таблет /Galaxy A7/ БЗДЦГ	Galaxy A9	2021.01.01	хэвийн	ш	4	655,700.00	2,622,800.00	2,010,813.32	611,986.68	Бусад хангамжийн материал	Машин, тоног төхөөрөмж
4	Таблет /Galaxy A7/ БЗДЦГ	Galaxy A10	2021.01.01	хэвийн	ш	4	655,700.00	2,622,800.00	2,010,813.32	611,986.68	Бусад хангамжийн материал	Машин, тоног төхөөрөмж
Машин тоног төхөөрөмжийн дүн								7,868,400.00	6,032,439.96	1,835,960.04		